



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 467

Улаанбаатар
хот

Монголын бүх ард түмний спортын XIҮ их
наадам зохион байгуулах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.5, 16.1-д заасныг тус тус үндэслэн
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монголын бүх ард түмний спортын XIҮ их наадмыг 2016 онд орон даяар
зохион байгуулсугай.

2. Спортын их наадмын анхан шатны тэмцээнийг орон нутагтаа зохион
байгуулах болон их наадамд оролцох тамирчдын зардлыг төсөвтөө тусган
санхүүжүүлэхийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Монголын бүх ард түмний спортын XIҮ их наадмыг батлагдсан төсөвтөө
багтаан зохион байгуулж, дүнг 2016 оны IҮ улиралд багтаан Засгийн газарт
танилцуулахыг Эрүүл мэнд, спортын сайдад даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Эрүүл мэнд, спортын сайдын
үүрэг хариуцагч бөгөөд
Монгол Улсын Шадар сайд

Ц.ОЮУНБААТАР